**БАТЛАВ:**

| | |
|---|---|
| ЭМЯ-НЫ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА, МОН-9218 ТӨСЛИЙН ЗАХИРАЛ | ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ |
| Д.БАЯРБОЛД | Б.НАРАНТУЯА |

***РЕЗИДЕНТ ЭМЧ НАРТ ЗОРИУЛСАН***
***ЦАХИМ СУРГАЛТЫН ХИЧЭЭЛ БЭЛТГЭХ ГЭРЭЭ***

**Дугаар:2022/05.....**

2022 оны 9 дугаар сар 14-ний өдөр Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх" буцалтгүй тусламжийн хэлэлцээр, Монгол Улсын Шадар сайдын баталсан 2021 оны 05 дугаар "Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцинаар түгээх, дархлаажуулах үйл ажиллагааны үндсний төлөвлөгөө", ЭМЯ болон АХБ хооронд 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан "Санамж бичиг"-ийн 9(j) дэх хэсгийг тус тус үндэслэн;

Нэг талаас АХБ-ны МОН-9218 төсөл, /цаашид "захиалагч" гэх/ түүнийг төлөөлж [illegible] төслийн зохицуулагч Дондог овогтой Жаргалсайхан,

Нөгөө талаас 9086331 регистрийн дугаартай Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "гүйцэтгэгч" гэх/ түүнийг төлөөлж Төлөвлөлт, тайлагналт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Баяраа овогтой Нямсүрэн нар /цаашид хамтад нь "талууд" гэх/ дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 9 сарын 14-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ /цаашид "гэрээ" гэх) байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Гүйцэтгэгч нь төсөл, хөтөлбөр, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд дотор хийж гүйцэтгэн, ажлын үр дүнг захиалагчид шилжүүлэх, захиалагч нь ажлын хөлсийг тодорхой хуваарийн дагуу олгох, ажлын гүйцэтгэлд хяналт тавихтай холбогдон үүсэх бусад харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

## ХОЁР. ГЭРЭЭГЭЭР ТОХИРОЛЦСОН АЖИЛ

2.1 Зорилго: <u>Дайчлагдан ажиллах</u> Резидент эмч нар, ЭМЯ-наас зөвшөөрсөн Коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуурийг хэрхэн зөв хэрэглэн Коронавирус илрүүлэх, хэрэглэсэн оношлуураа аюулгүй зөв устгах талаар сургалтын материал, шторк бэлтгэн олон нийтэд хүргэж сурталчилна.

2.2 Зорилт:

- Коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуурийг хэрхэн зөв хэрэглэх болон устгах талаар цахим сургалтын хичээл, шторк бэлтгэх,
- Цахим хичээл болон шторкийг түгээх, сурталчлах.

2.3 Хүрэх үр дүн:

- Резидент эмч нар цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах талаарх видео

сургалтын материалын сантай болно.

- ЭМЯ-наас зөвшөөрсөн, түргэвчилсэн оношлуураар Коронавирус илрүүлэх, хариуг зөв унших, хэрэглэсэн оношлуураа зөв устгах талаар мэдлэг хандлага эзэмшин, алдаа дутагдал гаргахгүй байх нөхцөл бүрдэнэ.

2.4 Хамрах хүрээ: Нийт резидент эмч нар
2.5 Хугацаа: 2022 оны 9 - 11 сар

## ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БОЛОН САНХҮҮЖИЛТ

3.1 Гэрээний үнийн дүн: 32,050,000 төгрөг. */гучин хоёр сая тавин мянга/*
3.2 Санхүүжүүлэгч: Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сангийн "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх" МОН-9218 төсөл
3.3 Гэрээний төлбөрт ажлын гүйцэтгэлд холбогдох материалын болон бусад зардал, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг гарч болох бүхий л төлбөр, зардлууд багтсан болно.
3.4 Гэрээ хүчин төгөлдөр болж, гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг захиалагч хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан төлбөрийг 100 хувь Төрийн сангийн 100900020405 тоот дансанд шилжүүлнэ.
3.6 Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсны дараа гэрээний үнийг нэмэгдүүлэх эрхгүй.

## ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

4.1 Цахим сургалтын хичээл бэлтгэх үйл ажиллагаа эхлэх хугацаа 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр, үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр байх ба ажлын гүйцэтгэлийн үргэлжлэх хугацаа 2 сар байна.
4.2 Гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хуанлийн тооллыг удирдлага болгоно.
4.3 Талууд гэрэний хугацааг нарийн чанд мөрдөх бөгөөд хугацааг сунгах тохиолдолд гэрээний хугацааг сунгах болсон шалтгаан болон нотлох баримтуудыг хасваргасан захиалагчид албан бичгээр мэдэгдэнэ.

## ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

5.1 Захиалагчийн эрх үүрэг:
5.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлж тайлан болон холбогдох баримт бичгийг бүрэн гүйцэт хүлээлгэн өгөхийг шаардана.
5.1.2 Ажлын гүйцэтгэлийн явц, үр дүнг шалгах бөгөөд "Төсөл хөтөлбөр, арга хэмжээний ажлын даалгавар"-т зааснаас зөрүүтэй, стандартын шаардлага хангаагүй чанаргүй, дутуу хийсэн ажлыг дахин гүйцэтгэхийг шаардах, шаардлага хангахгүй тайлан болон холбогдох материалыг хүлээн авахаас татгалзах, шаардагыг хүлээн аваагүй тохиолдолд гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж гарсан зардлыг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх, үйлдэгдэл төлбөрөөс суутгана.
5.1.3 "Төсөл хөтөлбөр, арга хэмжээний ажлын даалгавар"-т зааснаас зөрүүтэй, стандартын шаардлага хангаагүй, чанаргүй хийсэн, дутуу хийсэн ажлыг үнэ төлбөргүй буюу өөрийн зардлаар дахин нөхөж гүйцэтгэх, мөн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй ажлын төлбөрийг төлөхгүй байж болно.
5.1.4 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хоёр ба түүнээс дээш удаа биелүүлээгүй эсхүл гэрээнд заасан ажлын үр дүнг хүлээлгэн өгөх боломжгүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах санал гаргаж болно.
5.1.5 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээний хугацаанд багтаан хүлээн авна.
5.1.6 Гүйцэтгэгчид энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нь шаардах бүхий л мэдээ, мэдээлэл, зааварчилгаа өгнө.
5.1.7 Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлж хэрэгжүүлнэ.
5.2 Гүйцэтгэгчийн эрх үүрэг:
5.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагчаас шаардана.
5.2.2 Гүйцэтгэж байгаа ажилтай холбоотой нэмэлт мэдээлэл авна.

5.2.3 Гүйцэтгэгч нь захиалагчийн баталсан "Төсөл хөтөлбөр, арга хэмжээний ажлын даалгавар"-т заасан ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.
5.2.4 Ажил гүйцэтгэх явцад болон дараа илэрсэн зөрчил, чанарын доголдлыг тухай бүр өөрийн хөрөнгөөр арилгах, дахин эсхүл нөхөн гүйцэтгэнэ.
5.2.5 Гэрээний 4.1-т заасан хугацааг чанд баримтална.
5.2.6 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөрт багтаан үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, мөнгөн урьдчилгааны тайланг санхүүгийн анхан шатны баримын хамт АХБ-ны МОН-9218 төслийн нэгжид албан ёсоор хүргүүлэх бөгөөд албан бичгээр ирүүлнэ.
5.2.7 Захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй.
5.2.8 МОН-9218 төслийн санхүүжилтээр зохион байгуулсан бүтээсэн аливаа бүтээл, хөтөлбөр, арга хэмжээнд тус Азийн хөгжлийн банкны лого болон Ядуурлыг бууруулах Японы сангийн лого, мөн Эрүүл мэндийн яамны логоог заавал ашиглаж бичгэн тайлангийн толгой болон зураг, тайлангийн арын дэвсгэрт заавал бүтэн харагдахуйц байдлаар оруулж нотлох баримт болгон ирүүлнэ.
5.2.9 Захиалагчийн өгсөн шаардлага, заавар, зөвлөмжийг биелүүлнэ.
5.2.10 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлнэ.

## ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1 Гүйцэтгэгч энэхүү гэрээний 4.1-д заасан хугацаанд "Төсөл хөтөлбөр, арга хэмжээний ажлын даалгавар"-т заасан ажлыг эцэслэн дуусаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 хувиар тооцож алданги төлнө.
6.2 Талуудын аль нэг нь гэрээгээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөнөөс болж нөгөө талдаа хохирол учруулбал хохирлоо бүрэн хариуцна.

## ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1 Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
7.2 Хэрэв дээрх аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1 Гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно
8.2 Гэрээний талууд тохиролцон хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно
8.3 Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэж, гүйцэтгэгч тал нэг хувийг, захиалагч тал хоёр хувийг тус тус хадгалах бөгөөд эхүүд хууль эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.

## ЕС. НУУЦЛАЛ

9.1 Талууд энэ гэрээний дагуу мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд нууцлал задруулбал энэ гэрээний 6 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
9.2 Энэ заалт нь гүйцэтгэгчийн бүх ажилтан, төлөөлөгч, туслан гүйцэтгэгчид нэг адил хамаарна.

## АРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

10.1 Давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер гэх мэт байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр гэх мэт талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.
10.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээний үүргээ биелүүлэх хугацааг сунгах эсхүл тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл түр хойшлуулж болно. Энэ тухай гэрээнд бичгээр нэмэлт өөрчлөлт оруулна.

10.3 Энэхүү гэрээний 10.1-д заасан нөхцөл байдал үүссэн, дууссан талаар талууд нэг нэгдээ нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдээгүйн улмаас нөгөө талдаа учирсан хохирлыг буруутай тал хариуцна.
10.4 Бараа, материал, түүхий эдийн хомсдлын улмаас бий болсон үнийн өсөлт, үйлдвэрлэгч, бараа нийлүүлэгчийн шийдвэр, хязгаарлалт нь давагдашгүй хүчин зүйлд хамаарахгүй.

| | |
|---|---|
| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
| АХБ-ны МОН-9218 төслийн зохицуулагч Д.Жаргалсайхан | ЭМХТ-ийн Төлөвлөлт, тайлагналт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Нямсүрэн |
| АХБ-ны МОН-9218 төслийн худалдан авалт хариуцсан мэргэжилтэн Н.Хүрэлбаатар | |
| Хаяг: Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж, Засгийн газрын VIII байр, өргөтгөл-206 тоот<br>Утас: 7010-9218<br>Мэйл хаяг: khurelbaatar.n@moh.gov.mn | Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Зоригийн гудамж – 13Б, ЭМХТ, өөрийн байр<br>Утас:70128805<br>Мэйл хаяг: nyamsuren@hdc.gov.mn<br>Дансны дугаар: ЭМХТ 100900020405<br>Төрийн сан банк |

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА, МОН-9218
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
Д.БАЯРБОЛД

## РЕЗИДЕНТ ЭМЧ НАРТ ЗОРИУЛСАН ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХАД ШААРДАГДАХ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН ВИДЕО ХИЧЭЭЛ, ШТОРК БЭЛТГЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

2022.09.09

**Үндэслэл:**

Манай орны хувьд Ковид-19 халдварын цар тахлын тархалт буурч байгаа хэдий ч БНХАУ-д халдварын тархалт нэмэгдсэн, өөр шинэ дэд хувилбарууд гарсаар байгаа нь дахин цар тахлын давалгаа үүсэхгүй гэх баталгаагүйн дээр томуу, томуу төст өвчний тархалт нэмэгдэж Ковид 19 цар тахлын үүсгэгч болох Корона вирусийг шинж тэмдгээр ялган оношлоход улам бүр түвэгтэй болж байна.

Түүнчлэн Корона вирусийг оношлох түргэвчилсэн оношлуурууд олноор орж ирж эмийн сангуудаар зарагдаж байгаа бөгөөд эдгээр оношлуураар иргэд өөрсдөө гэртээ Коронавирус илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг авах тохиолдлууд ихээр гарч байна. Гэвч хэрхэн зөв сорьц авах, оношлуураа хэрхэн ашиглах, хариу унших зэрэг талаар үнэн зөв мэдлэг, мэдээлэл хомс байгаагаас сорьцыг буруу авах, улмаар хариу нь худлаа гарч байна.

Дайчлагдан ажиллах Резидент эмч нар, ЭМЯ-наас зөвшөөрсөн Коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуурийг хэрхэн зөв хэрэглэн Коронавирус илрүүлэх хэрэглэсэн оношлуураа аюулгүй зөв устгах талаар сургалтын материал, шторк бэлтгэн олон нийтэд хүргэн сурталчлах шаардлагатай байна.

**Зорилго:**

Дайчлагдан ажиллах Резидент эмч нар, ЭМЯ-наас зөвшөөрсөн Коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуурийг хэрхэн зөв хэрэглэн Коронавирус илрүүлэх хэрэглэсэн оношлуураа аюулгүй зөв устгах талаар сургалтын материал, шторк бэлтгэн олон нийтэд хүргэн сурталчилна.

**Зорилт:**

- Коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуурийг хэрхэн зөв хэрэглэх болон устгах талаар цахим сургалтын хичээл, шторк бэлтгэх,
- Цахим хичээл болон шторкийг түгээх, сурталчлах.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Эрүүл мэндийн хөгжлийн төв

**Санхүүжүүлэгч байгууллага:** АХБ, ЯБЯС-ийн "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх" 9218-MON төсөл

**Хамрах хүрээ:** Нийт резидент эмч нар

**Хугацаа:** 2022 оны 9-11 дүгээр сар

**Үйл ажиллагааны үе шатууд**

1. Хичээлүүд болон шторкны агуулга боловсруулах

2. Агуулгын дагуу зураг авалт хийх
3. Агуулгын дагуу сценари төлөвлөж зураг авах
4. Авсан зургуудыг эвлүүлж, видео хичээлийг найруулах
5. Компьютер график дээр ажиллах
6. Видео бичлэгт дуу оруулах
7. Видео хичээл, шторкны агуулга, сценарийг хянах

**Хүрэх үр дүн:**

- Резидент эмч нар цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах талаарх видео сургалтын материалын сантай болно.
- ЭМЯ-наас зөвшөөрсөн, түргэвчилсэн оношлуураар Коронавирус илрүүлэх, хариуг зөв унших, хэрэглэсэн оношлуураа зөв устгах талаар мэдлэг хандлага эзэмшин, алдаа дутагдал гаргахгүй байх нөхцөл бүрдэнэ.

Зөвшөөрсөн: Д.Жаргалсайхан / МОН-9218 Төслийн зохицуулагч/

Б.Нарантуяа /Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал/

Хянасан: Н.Хүрэлбаатар / МОН-9218 төслийн худалдан авалт хариуцсан мэргэжилтэн/

Б.Батцоож /ЭМХТ, Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга/

Боловсруулсан: Б.Нямсүрэн /ЭМХТ, Төлөвлөлт, тайлагналт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн/

Батлав.

Сангийн яамны хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын
дарга Ч.ЧИМИДСҮРЭН

_______________
(гарын үсэг)

# РЕЗИДЕНТ ЭМЧ НАРТ ЗОРИУЛСАН ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ШУУРХАЙ АРГА ХЭМ... АВАХАД ШААРДАГДАХ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН ВИДЕО ХИЧЭЭЛ ШТОРК БЭЛТГЭХ АЖЛЫН ТӨСӨВ

(2022 оны III улирал)

9218 МОН-Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх төсөл
(Тусламжийн дугаар, төслийн нэр)

Азийн Хөгжлийн Банк, Ял... Сангийн буца... тусламж
(Тусламжийн дугаар, төслийн нэр)

| Үйл ажиллагааны зардал | ТӨСӨВ | | Хянасан |
|---|---|---|---|
| | Орон нутагт хариуцах | Төслөөс хариуцах | |
| Сургалтын видео хичээл бэлтгэх зардал | | 10,150,000.00 | [illegible] |
| Шторк бэлтгэх зардал | | 19,500,000.00 | [illegible] |
| Бусад зардал | | 2,400,000.00 | [illegible] |
| | | 32,050,000.00 | [illegible] |

Санхүүжилт

Шилжүүлэх дүн

Хянасан:

ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга буюу Төслийн захирал Д.БАЯРБОЛД_______

СЯ-ны ХСХОГ-ын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.ГАНЗОРИГ_______

СЯ-ны Хөгжлийн санхүүжилтийн газрын Зөвлөх, Г.ӨЛЗИЙЖАРГАЛ_______

Төслийн зохицуулагч, Д.ЖАРГАЛСАЙХАН_______

Боловсруулсан:

Төслийн санхүүгийн ажилтан, "П.ОДМАА_______

Төслийн худалдан авалт хариуцсан мэргэжилтэн, Н.ХҮРЭЛБААТАР_______